

## **Сарын урьдчилсан төлөв**

### **2026 ОНЫ 05 ДУГААР САРЫН**

#### **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ**

##### **ТАНЫ АНХААРАЛД**

Дэлхийн цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэг нь 1991–2020 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг. Сарын цаг агаарын урьдчилсан мэдээнд сарын дундаж агаарын температур, нийлбэр хур тунадасны хэмжээг дараах дөрвөн бүс нутгаар тус бүрээр урьдчилан мэдээлнэ.


- o **Баруун** (Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Говь-Алтай, Баянхонгор)
- o **Төв** (Өвөрхангай, Архангай, Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв)
- o **Зүүн** (Хэнтий, Дорнод, Сүхбаатар)
- o **Говь** (Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говь-Сүмбэр)

Цаг агаарын үзэгдэл нутгийн 30 хувиас хэтрэхгүйгээр зурвас газраар ажиглагдах тохиолдолд "зарим газраар", 30-70 хувьд "ихэнх нутгаар", 70 хувиас дээш нутгийг хамрах тохиолдолд "нийт нутгаар" гэсэн нэр томъёо хэрэглэдэг. Дулааны улиралд агаарт болон хөрсний гадарга дээр температур 0°-аас бага болж хүйтрэхийг "цочир хүйтрэл" гэнэ.

Сар, улирлын урьдчилсан мэдээний талаар лавлах бол Ус, цаг уур, орчны судалгаа мэдээллийн хүрээлэнгийн 11-326606 утсаар холбогдох болон "Хиймэл оюун ухаан, тоон загварчлал, судалгааны хэлтэс" -ээс тодруулах боломжтой.


#### **Уур амьсгалын тойм**

Сарын дундаж агаарын температур ОЖД–аар Баян–Өлгийн нутаг, Увс, Архангайн баруун, Ховдын төв, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Хөвсгөлийн ихэнх, Өвөрхангай, Хэнтийн баруун хойд, Төвийн зүүн хойд хэсгээр 0...+6°C, Говь–Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд, Өмнөговь, Дорноговийн ихэнх нутгаар +12...+18°C, бусад нутгаар +6...+12°C дулаан байдаг (Зураг 1).



**Зураг 1. 5-р сарын агаарын температурын ОЖД, [°C].**


Тавдугаар сарын агаарын дундаж температурын олон жилийн явцаас онцолбол 1979–1982, 1985, 1987, 1988, 1991, 1993–1995, 2003, 2005, 2006, 2008, 2011, 2014–2016, 2019, 2021, 2023 онуудад ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байсан бол 1986, 1992, 1996, 1997, 1999–2002, 2007, 2009, 2017, 2018, 2020, 2022, 2024 онуудад дарааллан ОЖД–аас дулаан байсан байна. Харин 1995 оны 5-р сард ОЖД–аас 3°C–аар хүйтэн байсан нь 1979 оноос хойш тохиолдсон хамгийн хүйтэн, 2024 оны 5-р сард ОЖД–аас 4°C–аар дулаан буюу түүхэн дэх хамгийн дулаан сар болж өнгөрсөн байна (**Зураг 2**).



**Зураг 2. 5-р сарын агаарын температурын олон жилийн явц**


**[Улаан – ОЖД-аас дулаан, хөх – ОЖД-аас хүйтэн]**

Сарын нийлбэр хур тунадас ОЖД-аар Хангай, Хөвсгөл, Хэнтийн уулархаг нутгаар 20–30 мм, Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар 0–10 мм, бусад нутгаар 10–20 мм ордог байна (**Зураг 3**).



**Зураг 3. 5-р сарын нийлбэр хур тунадасны ОЖД, [мм]**

Харин 1979–1987, 1989-1991, 1993–1996, 2007-2009, 2017-2018 онуудад дарааллан ОЖД-аас бага байсан бол 1988, 2002–2003, 2005, 2010-2011, 2014, 2015, 2023-2025 онуудад ОЖД-аас харьцангуй ахиу хур тунадас орсон байна. 2018 онд нийт нутгийн дунджаар ОЖД-аас 8.5 мм-ээр бага тунадас орсон нь түүхэн дэх хамгийн хуурай 5-р сар болсон бол 2003 онд ОЖД-аас 17.6 мм-ээр ахиу тунадас орсон нь 1979 оноос хойшхи хамгийн ахиу тунадастай 5-р сар болсон байна (**Зураг 4**).



**Зураг 4. 5-р сарын нийлбэр хур тунадасны олон жилийн явц**

*[Ногоон – ОЖД-аас ахиу, шар – ОЖД-аас бага]*

#### **ЦАГ АГААРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ**


**Баруун аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур Увсын нутаг, Баян-Өлгий, Ховдын хойд, Завханы ихэнх хэсгээр ОЖД-ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байна (**Зураг 5**). Хур тунадас нийт нутгаар олон жилийн дунджийн орчим (**Зураг 6**) орох төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 7**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, хоёрдугаар арав хоногийн сүүл, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх бол нэгдүгээр арав хоногийн дунд, хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх төлөвтэй байна. Хур тунадасны хувьд хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн эхэн болон сүүлч үеүдэд ихэнх нутгаар хур тунадас орж, салхи салхи ширүүсч, шороон шуурга шуурч болзошгүй байна.

**Төвийн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур Хөвсгөлийн баруун хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байна (**Зураг 5**). Хур тунадас Сэлэнгэ, Төвийн зүүн хэсгээр ОЖД–аас бага, бусад нутгаар дунджийн орчим (**Зураг 6**) орох төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 8**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүлч, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх бол нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх төлөвтэй байна. Хур тунадасны хувьд хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар хур тунадас орж, салхи салхи ширүүсч, шороон шуурга шуурч болзошгүй байна.

**Зүүн аймгуудын нутгаар.** Энэ сард агаарын дундаж температур Дорнодын нутаг, Хэнтийн зүүн, Сүхбаатарын хойд хэсгээр ОЖД–ийн орчим, бусад нутгаар дунджаас

дулаан (**Зураг 5**), хур тунадас Хэнтий, Дорнодын нутаг, Сүхбаатарын ихэнх хэсгээр ОЖД–аас бага (**Зураг 6**) орох төлөвтэй байна. Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 9**)–д харуулав. Нэг, хоёр, гуравдугаар арав хоногийн эхэн үеүдэд ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх бол нэгдүгээр арав хоногийн дунд болон сүүлч, хоёр болон гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх төлөвтэй байна. Хур тунадасны хувьд хоёрдугаар арав хоногийн эхэн, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүлчээр ихэнх нутгаар хур тунадас орж, салхи салхи ширүүсч, шороон шуурга шуурч болзошгүй байна.


**Говийн аймгуудын нутгаар.** Энэ сард нийт нутгаар агаарын дундаж температур ОЖД–аас дулаан, хур тунадас ОЖД–ийн орчим байх төлөвтэй байна (**Зураг 5, 6**). Агаарын температур, хур тунадасны явцыг (**Зураг 10**)–д харуулав. Нэгдүгээр арав хоногийн эхэн болон сүүл, хоёрдугаар арав хоногийн эхэн болон дунд, гуравдугаар арав хоногийн эхээр ихэнх нутгаар ОЖД–аас дулаан байх бол нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар ОЖД–аас хүйтэн байх төлөвтэй байна. Хур тунадасны хувьд хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн сүүлчээр ихэнх нутгаар хур тунадас орж, салхи ширүүсч, шороон шуурга шуурч болзошгүй байна.




**Зураг 5. 2026 оны 5–р сарын агаарын дундаж температурын урьдчилсан төлөв, C<sup>0</sup>**

**[Д–агаарын температур ОЖД–аас дулаан,**

**Н–агаарын температур ОЖД–ийн орчим]**




**Зураг 6. 2026 оны 5-р сарын нийлбэр хур тунадасны урьдчилсан төлөв, мм**  
**[Н-хур тунадас ОЖД-ийн орчим,**  
**Б-хур тунадас ОЖД-аас бага]**



**Зураг 7. Баруун аймгуудын нутгийн 2026 оны 5-р сарын температур, хур тунадасны явц**

**[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,**


**үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]**



**Зураг 8. Төвийн аймгуудын нутгийн 2026 оны 5-р сарын температур, хур тунадасны явц**

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,


үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



**Зураг 9. Зүүн аймгуудын нутгийн 2026 оны 5-р сарын температур, хур тунадасны явц**

[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,

үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]



**Зураг 10. Говийн аймгуудын нутгийн 2026 оны 5-р сарын температур, хур тунадасны явц**

*[Хөх – агаарын дундаж температур ОЖД-аас хүйтэн, улаан – агаарын дундаж температур ОЖД-аас дулаан,*

*үргэлжилсэн хар зураас – агаарын дундаж температур, тасархай хар зураас – агаарын дундаж температурын ОЖД-аас хазайх хазайц, ногоон – хур тунадасны хэмжээ]*

### **ЗӨВЛӨМЖ**

Тавдугаар сард агаарын температур нутгийн баруун хойд болон зүүн хойд хэсгээр олон жилийн дунджийн орчим, бусад нутгаар дунджаас дулаан байх бол хур тунадас нутгийн зүүн хойд хэсгээр ОЖД-аас бага, бусад нутгаар дунджийн орчим байна. Сарын эхээр дулаарах боловч цаашдаа нэг болон хоёрдугаар арав хоногийн дунд, гуравдугаар арав хоногийн дунд болон сүүл үеүдэд ОЖД-аас хүйтэн, хур тунадас гуравдугаар арав хоногийн сүүлээр ихэнх нутгаар орох төлөвтэй байна.

Энэ сард нийт нутгаар салхи шуурганы давтагдал их байх магадлалтай ялангуяа зүүн аймгуудын нутгаар хур тунадас харьцангуй бага, хуурайшилт нэмэгдэх тул цаг агаарын гаралтай аюултай болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлэх, мөн болзошгүй ой хээрийн түймрээс сонор сэрэмжтэй байхыг анхааруулж байна.